

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийн баримт бичгийг боловсруулах явцад Хэнтий аймгийн**  
**иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн уулзалт**  
**2017 оны 10-р сарын 6**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банкны Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор Хэнтий аймгийн 16 иргэний нийгмийн байгууллагатай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;"><b>Дүн шинжилгээний баримт бичгийн талаарх санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</b></p>	<p><b>Боломж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Өвөг дээдсийн үлдээсэн баялаг нөөц, хөгжлийн боломж Хэнтий аймагт их бий.</li> <li>• Байгалийн баялгаас гадна уламжлалт түүх, соёл арвинтай учраас Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх асар их боломж бий.</li> <li>• Мал аж ахуй, байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, дотооддоо нийлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх олон боломж бий.</li> <li>• Дээд зэргийн органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаадын зах зээлд экспортлох явдал нь Монгол улсын бас нэг боломж юм.</li> </ul> <p><b>Сорилтууд:</b></p> <p><b>Боловсрол, хөдөлмөрийн зах зээл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын чанар, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй. Шинэ тоглоом, ном худалдаж авснаар боловсролын чанарыг сайжруулахгүй. Харин боловсролын салбарт ажиллаж буй хүмүүсийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэхэд хөрөнгө мөнгө зарцуулбал чанар сайжирна.</li> <li>• Шинэ сурах бичиг хэвлэх нь ашигтай бизнес болсон бөгөөд сурах бичгийн чанар, сурах бичгийг дамжуулан хэрэглэх дадалд сөргөөр нөлөөлж байна.</li> <li>• Сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол, техник мэргэжлийн боловсрол сургалт болон дээд боловсролын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.</li> <li>• Хүмүүс ажлын байрны шаардлагыг хангадаггүй. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа бодит үйлдвэрлэгч, мэргэжилтнүүд дутагдаж байна. Иргэд дээд боловсрол эзэмшдэг ч ажлын байранд шаардлагатай ур</li> </ul>

чадвар, техникийн чадамжгүй байдаг. МБС-ын байгууллагын сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулж, элсэлтийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

- Хөдөлмөрийн үнэлэмж доогуур учраас ажил хөдөлмөр эрхэлдэг зарим хүмүүс ядуу хэвээр байна. Цалин багатай учраас өдөр тутмын хэрэгцээгээ дөнгөж хангах байгаа хүмүүс эрүүл мэнддээ анхаарч чаддаггүй. Ажлын ачаалал маш өндөр, амралтын өдрүүдээр байнга илүү цагаар ажилладаг тул ажлаа сайн гүйцэтгэх урам зориг хөшүүрэг байдаггүй. Хүмүүс нэмэлт орлого олохын тулд ээлжийн амралтаараа Өмнөд Солонгост очиж ажилладаг маш их ядардаг, эрүүл мэнд муу болж байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд социализмын үед тогтоосон төрийн албаны цалингийн жишиг үзүүлэлтүүдийг дахин хянаж шинэчлэн тогтоох нь зүйтэй. Цалин хөлсийг хүмүүсийн чадавх, ур чадвар, ажлын гүйцэтгэлд тулгуурлан тогтоох ёстой.
- Иргэдийн хувьд хариуцлага хүлээх чадвар дутмаг, хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй. Монголын уламжлалт соёл, үнэт зүйлд тулгуурлан боловсрол, хөгжлийг хангахад анхаарлаа хандуулах нь зүйтэй.
- Хөдөө орон нутагт судалгаа явуулах санхүүжилт дутмаг. Иймд хүмүүс хэрхэн амьдардаг, хөдөө орон нутагт амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд юу хийх шаардлагатай талаар мэдээлэл байдаггүй.
- Ихэнх айл банкнаас өндөр хүүтэй зээл авч хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг төлдөг учраас ядуурлыг бууруулахын тулд их, дээд сургуулийг сургалтын төлбөргүй болгох хэрэгтэй. Зээлийг эргэн төлөхөд нэг өрх дунджаар 10 орчим жил зарцуулдаг.

#### **Нийгмийн халамж, хамгаалал**

- Ахмад настан, тэтгэвэр авагчид нийгмийн үйлчилгээ авч чаддаггүй, бизнесийн зээл авах шалгуурт тэнцдэггүй хасагддаг. Гэвч ахмад настангууд нийгэмд хувь нэмрээ оруулах потенциал чадавхитай байдаг учраас тэдний мэдлэг туршлагыг илүү ашиглах нь зүйтэй. Түүнчлэн урт наслалтын олон жишээнээс харахад Монголчууд 100 жил хүртэл амьдрах чадвартай.

#### **Эрүүл мэнд**

- Эрүүл мэнд нь ядуурлыг бууруулахад тэргүүлэх ач холбогдолтой. Монголчуудын дундаж наслалт төдийлөн нэмэгдэхгүй байна.

#### **Засаглал, төрийн алба, иргэний нийгэм**

- Төрийн албаны тогтвортой байдал хангалтгүй. Нэг мэргэжилтэн тогтвортой бодлого хэрэгжүүлж, үр дүнг нь харахын тулд 10-12 жил ажиллаж шаардлагатай боловч төрийн албан хаагчид байнга солигдож байгаагаас энэ нь боломжгүй юм. Төрийн албанд мэргэжлийн манлайлал, менежментийн дутагдалтай байна.
- Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагууд гүйцэтгэх боломжтой. ИНБ-уудыг дэмжиж чадавхжуулснаар төр, засгийн газартай хэлэлцээр хийж төр ба ард иргэдийн хооронд гүүр болж ажиллах чадавхтай болно. Хэнтий аймагт 100 орчим ИНБ байгаагаас 20 нь ИНБ-ын сүлжээнд хамрагддаг. ИНБ-ууд иргэдийн ойлголт ухамсарыг дээшлүүлэх, хүмүүст хүрч ажиллах, хяналт шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг гүйцэтгэх хүсэлтэй байдаг учраас тэдэнд боломжийг олгох шаардлагатай юм.
- Энэ оноос эхлэн Монголын залуучуудын хөгжлийн асуудал төр, засгийн газрын түвшинд яригдах болжээ. Залуучуудад зориулсан үйл ажиллагаа

явуулдаг агентлагуудын чадавх, нөөц бололцоо дутмаг учраас залуучуудын орон байр, ажил эрхлэлтийн асуудлыг шийдэж чадахгүй байна.

- Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй ИНБ-ууд харьцангуй шинэ учраас хөдөө аж ахуйн асуудлаар засгийн газарт дуу хоолойгоо сонсгож, суурь судалгаа, шинжилгээ хийж чаддаггүй. Монгол улс ХАА-н салбарыг тэргүүлэх чиглэл болгосон учраас ХАА-н салбарын ИНБ-уудын чадавхийг бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.
- Эмнэлэг болон бусад олон нийтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай ИНБ-ууд урт хугацаанд түншлэх хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай. Жишээлбэл, орон нутгийн эрүүл мэндийн ТББ нь аймгийн эмнэлэгтэй хамтран цэцэрлэгийн хүүхдүүдийн архаг өвчлөлийн судалгааг хамтран хийж эрүүл мэндийн боловсролыг хүүхдүүд нэг нэгнээсээ суралцах замаар эзэмших төслийг хэрэгжүүлж байна.
- Хөгжлийг доороос нь дээш буюу Багийн түвшинд эхлүүлэх нь зүйтэй. Гэвч Багийн нийгмийн хөгжлийн мэргэжилтэн, Багийн засаг дарга нар чадавх, нөөц бололцоо багатай байдаг. Багийн түвшинд цөөн тооны ажилтнууд олон мянган хүмүүст хүрч ажиллах, тэднийг мэдээллээр хангах, удирдах нь бэрхшээлтэй байдаг.
- Засгийн газрын бүтэц нүсэр том, засгийн газар нь ухаалаг бөгөөд авсаархан цомхон бүтэцтэй байх ёстой. Зарим агентлагуудад 2-хон хүний бүрэлдэхүүнтэй хэлтэс ч бий. Гурван сая хүн амтай улсад хэтэрхий олон тооны яамд байна.

#### **Хувийн хэвшлийн хөгжил**

- Хувийн хэвшлийг хөгжүүлэхийн тулд бага хэмжээний үйлдвэрлэл бус томоохон үйлдвэрүүдийг дэмжих хэрэгтэй. Жишээ нь Өмнөд Солонгост авто машин үйлдвэрлэдэг анхны гол үйлдвэрлэгчдийг л дэмжсэн байдаг.
- Орон нутгийн бизнес, ногоон хөгжлийг дэмжихийн тулд орон нутгийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгт мод нийлүүлэх мод үржүүлгийн газар гэх мэт ногоон хөгжлийн жижиг төслүүдэд санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж болно.
- Банкны зээлийн хүү өндөр байгаа нь бизнесийн хөгжилд томоохон сорилт болж байна. Хувийн хэвшлийг хөгжүүлбэл улс орон хөгжинө.
- Экспортын зах зээл, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлээгүйгээс орон нутгийн үйлдвэрлэл олон боломжийг алдаж байна.

#### **Эдийн засгийн өсөлт, ажлын байр**

- Хэнтий аймагт томоохон үйлдвэр байхгүй, ажлын байр дутагдалтай, ажилгүйдэл ихтэй, өндөр хүүтэй зээл зэрэг шалтгааны улмаас ядуурлын түвшин өндөр байна. Үйлчилгээний газар, ресторан, зоогийн газар, жижиглэнгийн худалдаа, зочид буудал нь аймгийн төвийн эдийн засгийн голлох үйл ажиллагаа юм.
- Орон нутагт ажлын байр дутмаг байгаа учраас орон нутгийн нөөцийг ашиглан ажлын байр бий болгоход чиглэсэн бодлого баримтлах хэрэгтэй. Жишээ нь хонины нэхийг орон нутагтаа худалдан авах боломжтой ч Хэнтий аймаг бусад аймгаас хонины нэхий худалдан авч байна.
- Залуучуудын ажилгүйдэл гол асуудал болсон. Томоохон төслүүд, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийг санхүүжүүлэх замаар ажлын байр бий болгох нь ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Хэнтий аймагт дэд бүтэц хангалтгүй, зах зээл багатай учраас томоохон хэмжээний үйлдвэрийг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал юм. Төрөл бүрийн ЖДҮ-ийг хөгжүүлэх нь Хэнтий аймагт илүү тохиромжтой.

- Эдийн засгийг хөгжүүлэх, ажлын байр бий болгохын тулд томоохон аж үйлдвэрийн төслүүдэд дэмжлэг үзүүлэхийг зарим оролцогчид санал болгож байв.
- Жижиг, бичил зээл, ЖДҮ болон хувь хүмүүст олгох санхүүжилтийг үргэлжлүүлэх, ингэхдээ сонгон шалгаруулалтыг илүү нээлттэй болгох, үр дүн, зардлын хяналтыг сайжруулах хэрэгтэй.
- Шинэ бизнес эрхлэгчид бус хэдэн жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийг дэмжих хэрэгтэйг зарим оролцогчид онцлов.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шаардлагатай. Хэнтий аймагт хөгжлийн бэрхшээлтэй 2800 орчим иргэд бий. Тэд ихэвчлэн ажил хөдөлмөр эрхлэх чадавхитай хүмүүс байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байгууллагууд долоо хоногт 25 цаг ажиллах боломжоор хангах ёстой байдаг. Гэвч хуулийн энэ зохицуулалт бодит амьдралд хэрэгждэггүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлийн шинэ ур чадвар эзэмшихийн тулд сургалтанд хамрагддаг боловч тоног төхөөрөмж, ажлын байрны хангамж дутагдалтай байгаагаас ажиллаж чаддаггүй.

#### **Уул уурхай**

- Гар аргаар уул уурхайн олборлолт явуулсны дараа байгаль орчны доройтол маш их байгааг шийдвэрлэх шаардлагатай.
- Ерөнхийдөө байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг боловсронгуй болгох, уул уурхайн салбарт хэрэгжүүлэх шаардлагатай.

#### **Байгаль орчин**

- Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх явдал гол асуудал болсон. Цөлжилттэй тэмцэх нь амьжиргаагаа хамгаалахад тусална.

#### **Хөдөө аж ахуй, мал аж ахуй**

- Монгол улс уламжлалт мал аж ахуйтай хөдөө аж ахуйн орон юм. Хэрэв бид уул уурхайн олборлолт явуулснаар амжилтанд хүрсэн бол хөгжиж дэвжих байсан, гэвч бодит амьдралд уул уурхайг хөгжүүлснээр ядуурал нэмэгдлээ. Мал бол нөхөн сэргээгдэх нөөц; Ашигт малтмалын нөөц тодорхой хугацааны дараа дуусна. Жишээ нь Батноров сум хавар ноолуураа зарж, мөнгөө олдог.
- Хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд суурилсан боловсруулах үйлдвэр бүхий ЖДҮ-ийг дэмжих хэрэгтэй.

#### **Аялал жуулчлал**

- 3-4 жилийн өмнө Хэнтий аймгийн хөгжлийн нэн тэргүүлэх ач холбогдол бүхий салбараар аялал жуулчлалын салбарыг сонгосон учраас ядуурлыг бууруулахын тулд энэ салбарыг цаашид хөгжүүлэх шаардлагатай. Энэ салбарыг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй юм.

<p><b>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн баримт бичигт тусгах санал</b></p>	<p><b>Салбарууд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Олон салбар, бага хэмжээний ЖДҮ-дэд санхүүжилтийг тараан хуваарилахын оронд томоохон төсөл, боловсруулах үйлдвэрүүд, дэд бүтцийг санхүүжүүлэх замаар ажлын байрыг бий болгох хэрэгтэй.</li> <li>• ДБГ уул уурхайн салбарт анхаарах шаардлагагүй. Харин ИНБ, иргэдийн оролцоог дэмжих ёстой. Ингэснээр уул уурхайн салбарын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, илүү тогтвортой байдлыг бий болгоно.</li> <li>• Аймгийн түвшинд хөгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий салбарууд нь: 1) аялал жуулчлал, 2) хүний хөгжил, 3) хөдөө аж ахуй, байгаль орчин</li> <li>• Үндэсний түвшинд хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүд: 1) засаглал, 2) хөдөө аж ахуй, байгаль орчин, 3) хүний хөгжил, ИНБ-уудын хөгжил, чадавхийг бэхжүүлэх, боловсрол 4) эрүүл мэнд, 5) банк санхүүжилт (ялангуяа зээлийн хүүгийн асуудлыг шийдвэрлэх)</li> </ul>
<p><b>Бусад</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсад ядуурлыг бууруулах чиглэлээр ДБГ-ээс үзүүлсэн дэмжлэгт олон тооны оролцогчид талархаж байв. Мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлж олгосон бага хэмжээний буцалтгүй тусламж, Тогтвортой амьжиргаа төсөл, Малын индексжүүлсэн даатгалын төсөл нь Хэнтий аймагт ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн гэж тэмдэглэв.</li> </ul>

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Төрийн удирдлага, засаглал/шинэтгэл	10	63%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	10	63%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	9	56%
— Эрүүл мэнд	7	44%
— Хүнсний аюулгүй байдал	7	44%
— Авилгатай тэмцэх	6	38%
— Санхүүгийн зах зээл	6	38%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	5	31%
— Эрх тэгш боломжоор хангах	5	31%
— Худалдаа, экспорт	5	31%
— Боловсрол	4	25%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	4	25%
— Хөдөөгийн хөгжил	3	19%
— Эдийн засгийн өсөлт	3	19%
— Гадаадын хөрөнгө оруулалт	3	19%
— Зам, тээвэр	3	19%
— Нийгмийн хамгаалал	3	19%
— Ус, ариун цэврийн байгууламж	2	13%

— Байгалийн нөөцийн удирдлага	1	6%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	1	6%
— Хотын хөгжил	1	6%
— Уур амьсгалын өөрчлөлт	1	6%
— Бусад:	1 (аялал жуулчлал)	6%
— Эрчим хүч	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	13	81%
— Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	13	81%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	9	56%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	6	38%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	4	25%
— Бүгд чухал	4	25%